

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

2023 ОНЫ 07 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДРИЙН НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2023 оны 07 дугаар сарын 18-ны өдөр

Улаанбаатар хот

	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг даалгавар НЭГ: Өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд инженерийн шугам сүлжээ, авто зам, тохижилт, ногоон байгууламжийн ажлын нэгдсэн төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлж, хэрэгжилтэд тогтмол Захирагчийн ажлын албанаас хяналт тавьж ажиллах.				
1	<p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын А/253 дугаар захирамжаар 55 хүний бүрэлдэхүүнтэй өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хэсэг байгуулагдаж, дүүргийн 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд 12 салбар 125 заалттай төлөвлөгөө боловсруулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.</p> <p>2023 оны 07 дугаар сарын байдлаар өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын явц 70.3 хувьтай байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Нийтлэг үйлчилгээний газар - 85 хувь 2. Боловсролын хэлтэс - 65 хувь 3. Онцгой байдлын хэлтэс - 54.5 хувь 4. Эрүүл мэндийн төв - 75.1 хувь 5. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК Чингэлтэй хэрэглэгчдэд үйлчлэх төв - 85 хувь 6. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 6-41 хувь 7. ОСНААУГ-ын Хэрэглэгчдэд үйлчлэх төв 7-39 хувь 8. “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК 91.6 хувь 9. “Найши трейд” ХХК -80 хувь 10. “Соёндрийм” ХХК - 70.5 хувь <p>Хувийн халаалтын уурын зуухнууд:</p> <ol style="list-style-type: none"> 11. Ану сервис” ХХК - 83 хувь 12. “Элбэг дулаан” ХХК- 75 хувь <p>Чингэлтэй дүүргийн Тохижилт үйлчилгээ ХХК, Нийтийн эзэмшлийн гудамж талбай, цэцэрлэгт хүрээлэнгүүдийн ногоон байгууламжит талбайд хийгдсэн ажил:</p> <ul style="list-style-type: none"> - Ургамлан хашлага хэлбэржүүлэлт 330 у/м, Мод, бут сөөг хэлбэржүүлэлт 156ш, Зүлэг тарилт 1534м2 талбайд, Зүлэг тайралт 7375м2 талбайд хийн, цэвэрлэгээнээс гарсан 14.1тн хог хаягдлыг ачиж, тээвэрлэн ажиллалаа. - Усалгаа 38 рейсээр 380 тн усаар усалгаа хийж ажиллалаа. - Жолооч 4, цэцэрлэгч 20 хүний бүрэлдэхүүнтэйгээр өдөр тутамдаа ажиллалаа. <p>Авто замын байгууламж шинээр хийх ажлын хүрээнд:</p>			70

	<ul style="list-style-type: none"> - 19 дүгээр хорооны нутаг дэвсгэрт "Гудамж сайжруулах" төсөл, арга хэмжээг "Тэгш буян зам" ХХК хэрэгжүүлэн авто зам, авто зогсоолын ажлыг хийж гүйцэтгэсэн. - 13 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Гудамж сайжруулах" төсөл, арга хэмжээг "Хишиг буянт зам" ХХК хэрэгжүүлэн байгалийн чулуун замын ажлыг хийж гүйцэтгэсэн. - 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт "Гудамж сайжруулах" төсөл, арга хэмжээг "Гоц тех" ХХК хэрэгжүүлэн 91 бетонон хучилттай авто замын ажлыг хийж гүйцэтгэсэн хүлээлгэж өгөөд байна. - Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар "Экспресс зам" ХХК-ийн хэрэгжүүлэн ажиллаж буй "Дэнжийн 1000-ын Цагаан байрны уулзвараас Хүчит шонхор захын уулзвар хүртэлх туслах замын өргөтгөл" төсөл арга хэмжээний явцад хяналт тавин ажиллаж байна. - Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар "Гэр хорооллын дундах авто замын дэд бүтцийг сайжруулах, шинэчлэх" төсөл, арга хэмжээг "Ди Вай Кэй Би" ХХК хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд газар чөлөөлтийн нөхөн олговрын зардлыг шийдээгүйгээс тус ажил нь зогсонги байдалтай байна. 			
<p><i>Үүрэг даалгавар ХОЁР: Өвөлжилтийн үед хүндрэл гарч болзошгүй сургууль, цэцэрлэг, эмнэлэг, халаалтын зуух, бусад барилга байгууламжийн цахилгаан, дулаан, шугам сүлжээний засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоо, судалгааг гарган, танилцуулах.</i></p>				
2	<p>Дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгт шаардлагатай хөрөнгө оруулалтын жагсаалт:</p> <p>-149 дүгээр сургууль Соронзон бойлер ашиглаж эхэлснээс хойш цахилгааны утас ачааллаа дийлэхгүй 2 удаа тасалдаж КТПН дээр нэг удаа гэмтэл гарсан. Улмаар мэргэжлийн байгууллагаар үзлэг, засвар хийлгэхэд цахилгааны хүчин чадлыг нэмэгдүүлэх, цахилгааны утас болон КТПН-ний бусад тоноглолыг хүчитгэх шаардлагатай гэж зөвлөсөн. УБЦТС-д хандан КТПН хүчитгэх техникийн нөхцөл гаргуулсан. Цаашид мэргэжлийн байгууллагаар төсөв, зураг хийлгэн тус засварын ажлыг хийлгэх хэрэгтэй байна.</p> <p>-37 дугаар сургууль Сангийн бүрэн засвар орох шаардлагатай саналаа нийслэлд хүргүүлсэн. Төсөв зураг шаардлагатай гээд төсөв зураг хийлгэхээр барилгын хөгжлийн төвд хүсэлтээ өгсөн байна.</p> <p>-72 дугаар сургууль Сургуулийн дотор дулааны шугам анги танхим халаах хэрэгслүүд олон жилийн ашиглалтын явцад муудан эвдэрч цоорсон халаалтын босоо шугамууд хагарч цоорсноос халуун ус гоожсон хүүхэд осолдох нөхцөл бүрдсэн, хаалт задвижжууд хуучирч муудаж барих чадваргүй болсон халуун ус их алдснаас зарим анги танхимын хана шал норж, шарлаж харлан шавар шохой хууларч унасан, дотор бохир усны шугамууд хагарч задарсан. Ариун цэврийн өрөөнүүд бохир алддаг үнэр ихтэй шалны зарим хэсэг норж дэвтсэн байдалтай байгаа.</p> <p>Мэргэжлийн хяналтын дүгнэлтийг 2022 оны 06 сарын 07ны өдөр гаргуулсан бөгөөд мэргэжлийн байгууллагаар 468.9 сая төгрөгийн төсөв хийлгэж, Хөрөнгө мөнгө шийдвэрлэх дэмжлэг хүссэн албан бичгийг НБГ, БЕГ, ЧДЗДТГ-т тус тус явуулсан.</p> <p>-24 дүгээр сургууль Сургуулийн А байрны дулааны насос солиход 3 сая төгрөг, 2 давхрын эрэгтэй 00-н өрөөний шугам задарч доод давхрууд руугаа ус алдаж байгааг засуулахад 2 сая төгрөг тус тус шаардлагатай</p> <p>- 174 дүгээр сургууль</p>			90

<p>Халаалтын мотор болон насос эвдэрсэн, мөн халаалтын тогооны тенг шатаж, (2011 онд тавьсан бөгөөд ашиглалтын хугацаа дуусч, засаж сэлбэх боломжгүй болсон) доголдол үүссэн тул шинээр солиход 3.8 сая төгрөг шаардлагатай.</p> <p>- 124 дүгээр сургууль</p> <p>2016 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдсан 4 бүлгийн өргөтгөлийн барилга нь дулаан алдагдалтай дээврийн хар цаас нь хууларч урагдсанаас дээврээс борооны ус их гоожсон. Нэн даруй засварлах шаардлагатай Дээврийн болон гадна фасад засварын төсөв 45 сая төгрөг. Хөрөнгө шийдвэрлүүлэх дэмжлэг хүссэн албан бичгийг Дүүргийн төрийн сан, боловсролын хэлтэст тус тус явуулсан.</p> <p>- 17 дугаар сургууль</p> <p>Орон нутгийн төсвөөс 5 сая төгрөг төсөвлөснөөр “Б” байрны труба сантехникийн асуудлаа шийдсэн боловч “А” байрны паар, сантехник олон жилийн элэгдлийн улмаас зэврэх, цоорох, хагарах зэрэг асуудлууд байнга гарч байна. Үүнд: 5 сая төгрөгийн төсөв хэрэгтэй байгаа.</p> <p>- 5 дугаар сургууль</p> <p>Засварын ажилд 14.6 сая төгрөг шаардлагатай /Дулаанаар хангагч ОСНААУГ-аас төсөвт өртгөө өгсөн ба ажлыг ОСНААУГ гүйцэтгэнэ/</p> <p>- 140 дүгээр сургууль</p> <p>Дээврээ хэсэгчлэн засуулахад 32.4 сая төгрөг шаардлагатай мөн цэвэр усны шугамын хоолой цоорч ус гоожоод байгааг төмрийн цавуугаар наасан солиулах шаардлагатай байна. Шугамаа нийтэд нь солиулхад 35.6 сая төгрөг шаардлагатай.</p> <p>- 57 дугаар сургууль</p> <p>Сургуулийн гадна хойд талд цэвэр усны шугам хуучирч, элэгдэж, хагарч, 20м шугам, 2 хаалт солих шаардлагатай. Сантехникийн материалд шаардлагатай 1 сая төгрөгийн тооцоо гаргасан.</p> <p>- 221 дүгээр цэцэрлэг</p> <p>Сургалт явуулдаг 5 бүлэг, хөгжмийн ерөөний аваарын хаалга нийт 6 ширхэг аваарын хаалгыг давхар вакум хаалга хийж, дулаалах хэрэгтэй байна. Үүнд 10.1 сая төгрөгийн төсөв шаардлагатай .</p> <p>- 222 дугаар цэцэрлэг</p> <p>Цэцэрлэгийн дээврээс дусаал гоожиж засварлах шаардлагатай байгаа. Мөн цэвэр усны шугамын хоолой муудаж ус шүүрч байгаа тул.Үүнд:12.5 сая төгрөгийн төсөв шаардлагатай.</p> <p>- 5 дугаар цэцэрлэг</p> <p>Халаалтын дотор шугам цоорсны улмаас хэрэглээний халуун усаа нээж чадахгүй байна. Хөрс рүү ус алдаж байгаа учраас засварлах нэн шаардлагатай нийт төсөв 35 сая төгрөг хэрэгтэй.</p> <p>- Насан туршийн боловсролын төв</p> <p>Чингэлтэй дүүргийн Насан туршийн боловсролын төвийн байранд дотоод засварын ажил хийгдэх мөн халаалтын системд гэмтэл гаран насос солих засвар хийгдэх шаардлагатай байгаа.</p> <p>Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төв:</p> <p>Хэрэглээний усны даралтын насос /Удаан хугацааны ашиглалтад үр ашиг сайтай байх/</p> <ul style="list-style-type: none"> - Дулаан дамжуулалтын гадаргуу хамгийн ихтэй. - 4 өөр төрөл : 11-РК, 21-РКР, 22-РККР, 33-РККРКР. - Өндрийн хэмжээс: 300 mm – 400 mm – 500 mm – 600 mm – 900 mm. 			
---	--	--	--

	<ul style="list-style-type: none"> - 100 мм -ээр өсөх 400 мм ээс 3000 мм хүртлэх 27 төрлийн уртын сонголттой. - DIN EN 10130 стандартыг хангасан DC 01 чанарын хүйтнээр цувисан хуулиатай хавтан33.3 мм -ийн усны суваг. - Гадаргууг нано-технологийор боловсруулсан зэврэлтийн эсрэг чанар өндөр. - Экологийн усанд суурилсан нойтон будаг болон RAL 9016 давирхай полиэстр материалнай цахилгаан нунтаг будаг. - Ажиллах хамгийн өндөр температур 110 өС.4 x R ½" ба 6 x R ½" холболт. - Угсралтын бүрдэлдэхүүн болох хий авагч, битүү таг, тэлэгч, шрүп, хуванцар жийрэг зэрэг иж бүрдэл дагалддаг.13 бар даралтанд тестэлдэг. <p>Ажиллах үеийн дээд даралт 10 бар.CE, EN 442, GOST - R, UKR SEPRO, ISO 9001, ISO 14001, ISO 18001 стандартуудыг хангасан өндөр чанарын бүтээгдэхүүн/ ЧЭМТ-ийн Хайлааст Хүүхдийн салбарын Кабинетын дотор халаалтын паар /гурвалсан ажиллагаатай хосолмол байх/ Ус халаагуурын бойлер шаардлагатай байгаа.</p> <ul style="list-style-type: none"> - Даралтын насос нь автоматаар усыг шугамд шахах зориулалттай. - Ураалаг мэдрэгчүүд нь усгүй ажиллахын эсрэг горимтой - Дотор мотор, эд ангиуд нь зэсээр хийгдсэн. - Зэврэлтийн эсрэг энамалед түрхлэгтэй тул усны хатуулгаас хамгаална. - Даралт тогтвортой гаргана. - Даралтын датчик чанар өндөр <p>Нийт төсөв: 12,250,000</p>			
<p><i>Үүрэг даалгавар ГУРАВ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” А/378 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж, ажлын уялдаагаа, хангаж, тулгамдсан асуудлыг тухай бүр шийдвэрлэн, гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах.</i></p>				
3	<p>Дүүрэгт Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2023 онд хэрэгжиж байгаа 59 төсөл арга хэмжээний явц, гэрээний үүргийн хэрэгжилтэд сар бүр хяналт тавин биелэлтийг тухай бүр тайлагнан ажиллаж байна. Нийслэлийн Замын хөгжлийн газар, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар, Барилгын хөгжлийн төвд дүүргийн нутаг дэвсгэрт хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт тавин ажиллаж, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланг улирал бүр аван, хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компаниудын хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн гүйцэтгэлийн тайланг авах тухай албан бичгийг гүйцэтгэгч тус бүрд хүргүүлэн, 2023 оны хагас жилийн байдлаар хүлээн аван ажиллаж байна.</p>			70
<p><i>Үүрэг даалгавар ДӨРӨВ: Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, эмнэлгийн барилга байгууламжийн болон инженерийн шугам сүлжээнд хийгдэх урсгал засварын ажлуудыг эрчимжүүлж ажиллах.</i></p>				
4	<p>Дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэгт хийгдэж буй засварын ажлууд: 17 дугаар сургууль: Б байрны ариун цэврийн өрөөний урсгал засварыг дотоод нөөцөөрөө хийсэн. 24 дүгээр сургууль:</p>			90

	<p>Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2, 3-р давхрын эмэгтэй ариун цэврийн өрөөний засвар тохижилтын ажил 2023 оны 07 дугаар сарын 18-ны өдрөөс хийгдэж эхэлсэн. Мөн төсвийн хөрөнгөөр нийтийн эзэмшлийн талбайн хана, шал, шатны будгийн ажил хийгдэж байна.</p> <p>37 дугаар сургууль: Нийслэлийн хөрөнгө оруулалтаар ариун цэврийн өрөөний засвар эхэлсэн. Гүйцэтгэл 35% байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийслэлийн өмчийн газрын хяналтын дагуу Хөл бөмбөгийн засвар тохижилтын ажил 40% гүйцэтгэлтэй хийгдэж байна.</p> <p>39 дүгээр сургууль: Хичээлийн “А” байр 1969 онд ашиглалтад орсон. Нийслэлийн хөрөнгө оруулалтаар ариун цэврийн өрөөний засвар 2023 оны 07 дугаар сарын 05-ний өдөр эхэлсэн бөгөөд 7 өрөөг засварлаж гүйцэтгэл 60% явж байна. Гадна фасадын ажил Нийслэлийн цэвэр агаар сангийн нэмэлт санхүүжилтийн хөрөнгө оруулалтаар 2023 оны 06 дугаар сарын 15-аас эхэлсэн. нийт 808.0 сая төгрөгийн санхүүжилтээр цонх, цохны тавцан, фасад, үерийн хаяавч, агааржуулалтын хоолой, суурин дулаалга, суваг гэх мэт ажлыг хийж гүйцэтгэнэ. 08 дугаар сарын 10-нд дуусгах төлөвтэй байна. Ажлын гүйцэтгэл 60% явагдаж байна.</p> <p>117 дугаар сургууль: Нийслэлийн хөрөнгө оруулалтаар ариун цэврийн өрөөний засвар эхэлсэн. Гүйцэтгэл 50%-тай явагдаж байгаа ба суултуур, хаалга, сангийн хаалт хийх дутуу байна. Нийтийн эзэмшлийн талбайд 08 дугаар сард урсгал засвар хийгдэх төлөвлөгөөтэй байна.</p> <p>72 дугаар сургууль: Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд сургуулийн А байрны 1 давхрын ариун цэврийн өрөөний суултуур бөглөрч шугам сүлжээнээс ус алддаг байсныг дүүргийн хөрөнгө оруулалттай тендэр зарлагдсан байгууллагад хүсэлт гарган иж бүрэн засвар хийгдэж байна.</p> <p>57 дугаар сургууль: “Цэвэр агаар” төсөл Улсын хөрөнгө оруулалтаар сургуулийн дулаалгын фасадын засварын ажил /дээвэр, бүх цонх солигдсон, суурийн дулаалга, ус зайлуулагч хоолой, гадна хаалга, гадна фасад/ 80% гүйцэтгэлтэй хийгдэж байна.</p> <p>Орон нутгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн хөл бөмбөгийн талбайн иж бүрэн засвар, тохижилтын ажил бүрэн хийгдэж дууссан.</p> <p>Нийслэлийн хөрөнгө оруулалтаар ариун цэврийн өрөөний засварын ажил эхэлж 20% гүйцэтгэлтэй байна.</p>			
<p><i>Үүрэг даалгавар ТАВ: Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Үерийн хор уршгийг арилгах зарим арга хэмжээний тухай” А/806 дугаар захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.</i></p>				
5	<p>Дүүргийн 19, 24 дүгээр хорооны үерийн аюулд өртөж болзошгүй иргэдэд урьдчилан сэргийлэх мэдээ мэдээлэл, заавар зөвлөмжийг Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн бэлтгэл ээлжийн 15 алба хаагч, Дотоод хэргийн их сургуулийн Онцгой байдлын сургуулийн 4 сонсогч, Тоyota Наюе маркийн автомашинтай үерийн эрсдэлтэй бүсэд байршилтай 120 өрхийн 162 иргэнд брошур материал болон мэргэжлийн заавар зөвлөгөө өгч ажилласан.</p> <p>Үер, усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, постер, шторк бэлтгэн дүүргийн 1-24 дүгээр хорооны дотор байрлах дэлгэцүүдээр давтагдсан тоогоор 120 удаа, хэлтсийн фэйж хуудас болон сайтад нийт 24 мэдээ, байршуулан нийт 6420 иргэнд хүргэн ажиллаж байна.</p> <p>Чингэлтэй дүүргийн Нийслэлийн засаг захиргааны III байрны лед дэлгэц, МН Товэр төвийн</p>			90

	<p>гадна талбайн лед дэлгэц, дүүргийн 7-24 дүгээр хорооны цахим дэлгэц, Алтжин бөмбөгөр худалдааны төвийн цахим дэлгэцээр тус бүр өдөрт 5-6 удаагийн давтамжтайгаар нийт 16 удаа хүргэж сурталчилж ажилласан.</p> <p>Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, үүрэг гүйцэтгүүлэх тухай” А/59 дүгээр тушаалаар Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Ангиллын сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч гал сөнөөгч, ахлах ахлагч М.Мөнхжаргал, Ангиллын сургалт сурталчилгаа, бие бүрэлдэхүүний сургалт хариуцсан мэргэжилтэн, дэслэгч С.Урантөгс 2023 оны 07 дугаар сарын 12, 16-ны өдрүүдэд Баянгол дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 6 албан хаагч, 1 автомашин, давхардсан тоогоор нийт 12 албан хаагч, 2 автомашинтай, 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрөөс 21-ний өдрийн хугацаанд Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 6 албан хаагч, 1 автомашин, давхардсан тоогоор нийт 30 албан хаагч, 5 автомашинтай хамтран Нийслэлийн Онцгой байдлын газраас гаргасан усны ослоос урьдчилан сэргийлэх хөдөлгөөнт эргүүлээр яармагийн гүүрнээс маршалын гүүр хүртэлх 6.2 км газарт эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажиллаж байна. Эргүүлээр маршалын гүүрний доор амарч зугаалж байгаа нийт 67 иргэн, 38 хүүхдэд үер усны аюулаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж хүргэн ажилласан.</p> <p>Улаанбаатар хотод ширүүн болон усархаг бороо орсны улмаас дүүргийн 19, 24 дүгээр хорооны нутаг дэвсгэрт байрлах сэлбэ голын эргээс хальж олон тооны айл өрхийн гэр болон хашаа байшинд үерийн ус нэвтэрч орсныг дүүргийн Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн 262 албан хаагч, 9 механизм, 20 ачааны автомашинтайгаар 2023 оны 7 дугаар сарын 04-ээс 0 7-ны өдрүүдэд дүүргийн 19, 24 дүгээр хорооны үерийн усанд өртсөн 273 өрхийн 650 гаруй иргэний аюулгүй байдлыг ханган 1.5км-ийн урттай даланг 156 машин шороо асгаж, хүчитгэх ажлыг шуурхай зохион байгуулан ажилласан.</p> <p>Тус ажлыг зохион байгуулахад дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 41 албан хаагч 5 тээврийн хэрэгсэл, Цагдаагийн газрын 35 албан хаагч 3 тээврийн хэрэгсэл, ЗДТГ-ын Цэргийн штабын 5 албан хаагч, дүйцүүлэх 13, 1 тээврийн хэрэгсэл, "Тохижилт үйлчилгээний" ХХК-ийн 45 албан хаагч, 1 ковш, 1 экскаватор, 15 ачааны машин, "Наши трейд" ХХК-ийн 19 албан хаагч, 1 экскаватор, 5 ачааны машин, ЗДТГ, хороодын ажлын албаны 104 албан хаагч, 3 тээврийн хэрэгсэлтэйгээр үүрэг гүйцэтгэн ажилласан байна.</p> <p>Онцгой байдлын хэлтсээс Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2020 оны 22 дугаар тушаалын хүрээнд Дүүргийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн “Гамшгийн хор уршигт дүн шинжилгээ хийж, учирсан хохирлыг тогтоох дэд ажлын хэсэг байгуулах тухай” А/224 дүгээр захирамжийг гарган ажлын хэсэг байгуулж үерийн улмаас учирсан хохирлыг тогтоох хохирол хэрэгцээний шуурхай үнэлгээг хийж ажиллаж байна.</p>			
<p><i>Үүрэг даалгавар ЗУРГАА: Зуслангийн бүсэд зөвшөөрөлгүй барилга, байгууламж барьж байгаа асуудалд хяналт тавьж ажиллах.</i></p>				
6	<p>Зуслангийн бүсэд зөвшөөрөлгүй барилга, байгууламж барьж байгаа эсэхэд хяналт тавихаар дүүргийн Газар зохион байгуулалтын албанаас барилга байгууламжийн судалгаа гаргуулан ажиллаж байна.</p>			30

Үүрэг даалгавар ДОЛОО: Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/490 дүгээр захирамжийн дагуу 40 байршилд 3*3 сагсан бөмбөгийн талбай байгуулах ажлыг эрчимжүүлж ажиллах.

7	Нийслэлийн хөрөнгө оруулалтаар дүүргийн нутаг дэвсгэрт хийгдсэн 3x3 сагсан бөмбөгийн 7 талбайг хүлээн авч ашиглалтад оруулсан.			90
---	--	--	--	----

ЗАСАГ ДАРГА

Н.БАТСҮМБЭРЭЛ

ТАНИЛЦСАН: НИЙСЛЭЛИЙН ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

П.БАЯНБААТАР

ТАНИЛЦСАН: ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Л.БАЯРМАА

ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН

Г. ГООМАРАЛ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:

ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Э.ХУЛАН

НЭГТГЭСЭН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

Т.ТҮВШИНЖАРГАЛ